




ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг аж үйлдвэрийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол ус, цахилгаан, дулаан хангамжийн салбар болоод харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

'Southwest Airlines' компани өөрийн "Boeing 737 Max" онгоцны программ хангамжийг засварласан талаар мэдээлж, тус компанийн хувьцааны ханш эргэн өсжээ. Зохицуулагч байгууллагууд 'T-mobile' болоод 'Sprint' компаниудын нэгдлийг ихээхэн эргэлзээтэй хүлээж авч байгаатай холбогдуулан тус компаниудын хувьцааны ханш буурсан байна. 'Google' компанийн толгой компани болох 'Alphabet' компанийн хувьцааны ханш унажээ.

АНУ-ын эдийн засгийн өсөлт сүүлийн хоёр улирал дараалан саарсан үзүүлэлттэй гарлаа. АНУ-ын Худалдааны яамны залруулсан мэдээллээр 2018 оны санхүүгийн жилийн IV улиралд тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн өмнө нь мэдээлж байснаар 2.6 хувиар биш, 2.2 хувиар өссөн байна. Энэ нь өмнөх улирлаас тааруу үзүүлэлт болоод зогсохгүй урьдчилсан таамагт хүрээгүй дүн болжээ. Үүнд эдийн засгийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг иргэдийн хэрэглээний өсөлт саарсан нь голлон нөлөөлсөн байна. Мөн компаниудын орлого 2017 оноос хойш анх удаа буурсан нь эдийн засгийн өсөлт саарах дараагийн шалтгаан болжээ.

Европ: Европын бүсийн STOXX Europe 600 индекс болоод Их Британийн FTSE 100 индекс өсөлттэй хаагдлаа.

Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэйн өргөн барьсан 'Brexit' төслийг тус улсын Парламент гурав дахь удаагаа няцаалаа. Их Британийн Парламентын гишүүд BREXIT-ийн боломжит найман хувилбараар явуулсан санал хураалтаар аль ч хувилбарт үнэмлэхүй дэмжлэг үзүүлсэнгүй. Санал хураалтаар шийдэлд хүрээгүй тул Их Британийн эрх баригчид нарийвчилсан жагсаалт гаргаж даваа гарагт дахин санал хураахаар болсон байна. Ингэснээр евро болон фунтийн ханш ам.долларын эсрэг суларчээ.

Европын бүсийн эдийн засаг үргэлжлэн муудсаар байвал Европын төв банк бодлогын хүүгээ өсгөхгүй байх талаар мэдээлж, ХБНГУ-ын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын ханш буурсан байна.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 2 орчим хувир буурлаа.

3-р сарын 24-ний өдөр тус улсын Засгийн газар 2019 оны төсвийг 101.46 их наяд иен байхаар батлав. Энэ тус улсын төсөв 100 их наяд иенийг давж буй анхны тохиолдол юм. Төсвийн 1/3 нь эрүүл мэнд, тэтгэвэр зэрэг нийгмийн халамжийн зориулалтаар ашиглагдах юм.

БНХАУ: АНУ болон БНХАУ удахгүй худалдааны зөвшилцөлд хүрнэ гэсэн хүлээлт өндөр байгаа ажээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,852.24	-1.12% ▼
Dow Jones	АНУ	25,928.68	1.67% ▲
S&P 500	АНУ	2,834.40	1.20% ▲
Nasdaq	АНУ	7,729.32	1.13% ▲
S&P/TSX	Канад	16,102.09	0.08% ▲
FTSE 100	Их Британи	7,279.19	0.99% ▲
S&P/ASX 200	Австрали	6,180.70	-0.23% ▼
Nikkei 225	Япон	21,205.81	-1.95% ▼
Hang Seng	Хонг Конг	29,051.36	-0.21% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.65
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.03
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.23
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.65
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.75
DBM' 2023	USD	7.250%	104.33
TDBM' 2020	USD	9.375%	104.49

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.495	-0.00 ▼
Libor 3M	2.600	-0.01 ▼
Libor 6M	2.660	-0.01 ▼
Libor 1YR	2.710	-0.08 ▼
US 2YR Bond	2.294	-0.02 ▼
US 3YR Bond	2.243	0.01 ▲
US 5YR Bond	2.266	0.03 ▲
US 10YR Bond	2.433	0.00 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.03.29	Өөрчлөлт
USD	2,631.51	0.02% ▲
CNY	391.61	-0.25% ▼
EUR	2,955.84	-1.34% ▼
RUB	40.62	-1.57% ▼
KRW	2.32	-0.43% ▼
JPY	23.76	0.04% ▲
CAD	1,959.06	-0.55% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,292.38	-1.62% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	15.12	-1.98% ▼
Зэс	USD/lb.	293.60	3.29% ▲
Нүүрс	USD/MT	84.63	-4.07% ▼
WTI газрын тос	USD/bbl.	60.14	1.86% ▲
Brent газрын тос	USD/bbl.	68.39	2.03% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.66	-3.27% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. II	6.90%
Бодлогын хүү	2019. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. II	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. II	12.00%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. II	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. II	17.00%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. II	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 65 компанийн 724.9 сая төгрөгийн 3,025,324 ширхэг хувьцаа арилжигдав.

“Жинст-Увс” /JIV/ компанийн хувьцаа 16.42%-аар буюу хамгийн ихээр өсч 1,978.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Баялаг налайх” /BNB/ компанийн хувьцаа 18.88%-аар буурч 333.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


3-р сарын 29-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,452.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,852.24 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.12%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	724.9
Зах зээлийн үнэлгээ	2,452,754.8

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,852.24	-1.12% ▼
MSE I индекс	9,458.48	-3.58% ▼
MSE II индекс	8,322.03	-0.23% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	201,429	126,197,909
ЛэндМН ББСБ	1,616,165	109,485,425
Жинст Увс	47,161	81,840,926
Таван толгой	10,449	75,165,280
Улсын их дэлгүүр	150,184	70,961,292

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Жинст-Увс	1,978.00	16.42% ▲
Баянталбай	74.75	15.00% ▲
Нако түлш	115.00	15.00% ▲
Монгол нэхмэл	2,735.00	14.92% ▲
Баян-Алдар	1,001.00	8.80% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Баялаг налайх	333.00	-18.88% ▼
Стандарт агрикалчер групп	250.00	-16.67% ▼
Бинсэ	340.00	-15.00% ▼
Ган хийц	12,490.00	-13.02% ▼
Увс чацаргана	448.31	-9.98% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Апекс капитал	200,096,396
Ард секюритиз	184,648,628
Ард капитал групп	180,556,308
Голомт капитал	136,813,272
Бумбат-Алтай	127,219,050

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	631.62	672,158
Таван толгой	7,225.00	380,506
МИК	11,770.00	243,749
Говь	293.60	229,041
Сүү	212.26	73,017

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.15-с
2	LEND	ЛендМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.05.01-ний дотор
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюты фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.05.01-ний дотор
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.01-с
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.12.31-ний дотор
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HHS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Нэгдүгээр улиралд хоёр IPO

Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны эхний улиралд үнэт цаасны зах зээл дээр хоёр IPO буюу шинэ хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргах зөвшөөрлийг олголоо. Хорооноос зөвшөөрсний дагуу "Ард кредит ББСБ" ХК-ийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон бол удахгүй "Монос хүнс" ХК-ийн хувьцаа зах зээлд гарна.

Мөн Хороо энэ улиралд нэр бүхий хоёр компанид хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, мөн тооны хуулийн этгээдийг үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын болон хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн болон гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн зэргээр гурван компанийн бүртгэлд өөрчлөлт оруулжээ. Түүнчлэн, номинал дансаар дамжуулан харилцагчдад брокерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг үнэт цаасны гурван компанид олгож, мөн тооны хуулийн этгээдэд нийт долоон салбар шинээр байгуулахыг зөвшөөрсөн байна.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

МХБ-д бүртгэлтэй 8 компани нэмж хувьцаа гаргах эсэхээ IV сард шийдвэрлэнэ

4-р сард Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 133 компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийхээр товллоод байна. Эдгээрээс найман компани нэмж хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэхээр хүлээгдэж байгаа ажээ.

Тухайлбал, "Шарын гол" компани өр төлбөрөө хувьцаагаар солихын тулд нэмж хувьцаа гаргахаар төлөвлөж байна. Тус компанийн хувьцааны ханш энэ сард унаж, 1,611 төгрөгтэй тэнцсэнээр сүүлийн 10 жилийн доод түвшин рүү унаад байгаа юм. Үүнээс хойш ханш нь дөрвөн арилжаа дараалан өсөж, 1,955 төгрөг болоод байна.

Үүнээс гадна "Баян-Алдар" болон "Дархан гурил тэжээл" компани хувьцаагаа хувааж, нэмж хувьцаа гаргахаар төлөвлөжээ. "Баян-Алдар" компани "Монгорүматрикс гинко"-той нэгдэж Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа явуулахаар болсон байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хувьцаагаа хувааж, нэмж хувьцаа гаргахаар төлөвлөж байгаагаа мэдээллээ. Тус компанийн нэгж хувьцааны ханш сүүлийн байдлаар 1,001 төгрөг байна. Ингэснээр зах зээлийн үнэлгээ нь 19.9 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа юм.

Харин "Дархан гурил тэжээл" компани мөн ижил хувьцаагаа хувааж, нэмж хувьцаа гаргахаар төлөвлөж байна. Тус компани 2018 онд 2.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь алдагдлын хэмжээ нь жилийн өмнөхөөс 17 орчим хувиар буурсан үзүүлэлт болжээ. "Дархан гурил тэжээл" компани 2018 онд хөрөнгийн үнэлгээгээ дахин хийлгэснээр орлогын нийт дүн нь 32 тэрбум төгрөг давсан байна. Харин хувьцааны ханш нь 1,051 төгрөг байгаа нь зах зээлийн үнэлгээг нь 650 сая төгрөг хүрэхгүй болгож байгаа аж.

Үүнээс гадна "Хасу-Мандал" болон "Азык" компаниуд компанийн хэлбэрээ өөрчлөн Хязгаарлагдмал хариуцлагатай компани болохоор төлөвлөжээ. Мөн "Нако түлш" компани хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хурлаар компаниа татан буулгах төсөл, журмыг хэлэлцэн баталж, үлдэх эд хөрөнгийг хуваарилах журмыг батлахаар төлөвлөж байгаа аж.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

"Баян-Алдар" ХК-ийн оноосон нэрийг "Баян-Алдар ББСБ" ХК болгон өөрчиллөө

"Баян-Алдар" ХК-ийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 56 тоот албан хүсэлт, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн дүрмийн 8.10.11 заалт, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн гаргасан Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/24 тоот тушаалаар "Баян-Алдар" ХК-ийн оноосон нэрийг "Баян-Алдар ББСБ" ХК болгон өөрчиллөө.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

"ЛэндМН ББСБ" 2019 онд 6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөжээ

"ЛэндМН" компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 3-р сарын 23-ны өдөр болж, дөрвөн сая хувьцаагаа эргүүлэн худалдан авах шийдвэр гаргасан байна.

"ЛэндМН ББСБ" 2018 оны 3-р сард буюу одоогоос нэг жилийн өмнө нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгож, хөрөнгө оруулагчдаас таван тэрбум төгрөгийн санхүүжилт татаж байсан юм. Тус компанийн хувьцааны ханш хамгийн сүүлийн байдлаар 69.5 төгрөг байгаа нь нэрлэсэн үнээсээ 2.8 дахин өссөн үзүүлэлттэй байгаа ажээ. Хувьцаат компани болсноос хойш хувьцааных нь эрэлт өндөр байсан төдийгүй арилжааны идэвхээр тэргүүлэгчдийн нэг байсаар байна. Ингэснээр Монголын Хөрөнгийн бирж 2019 онд үнэт цаасыг нь I ангилалд бүртгэж, "Топ 20" индексэд багтаасан юм.

"ЛэндМН ББСБ" 2018 онд 2,560 орчим сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. 2019 онд ашгийн хэмжээгээ 2.3 дахин өсгөж, зургаан тэрбум төгрөг хүргэхээр зорьж байгаа аж. Үүний тулд урт хугацаатай өндөр дүнтэй зээл гаргахаас гадна жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл олгож, бараа татан авалтын зээлийн үйлчилгээг захад гаргахаар болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

"Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн"-ээс ирүүлсэн мэдэгдэл

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) нь Хөндий Алтны Төслийн 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг 2019 оны 4 сарын 14-ний дотор Сэндсторм Гоулд Лимитед компаниас \$1.2 сая канад доллараар худалдан авахаар болсон байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

"Гермес центр" ХК болон "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

"Гермес центр" ХК-ийн 2018 оны сүүлийн хагас жилийн ногдол ашиг болох нэгж хувьцаанд 3 төгрөг 42 мөнгө тараасныг 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр, "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 90 мөнгө тараасныг 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд тус тус байршууллаа.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Цахимаар данс нээх үйлчилгээг нэвтрүүлээ

"ҮЦТХТ" ХХК нь үнэт цаасны дансыг нээх үйл ажиллагаагаа цахимжуулж API /цахим холболт/-р дамжуулж ҮЦК-иудаас мэдээлэл авч шинээр үнэт цаасны дансыг онлайнаар нээж эхэллээ. Та өөрийн сонгосон ҮЦК-даа хандан онлайнаар үнэт цаасны дансаа нээлгэх боломжтой боллоо.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



Гуравдугаар сард 91 кг алт худалдан авлаа

Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 26-ны ээлжит бус чуулганаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, алтны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 5% болгосон.

Тус хуулийг Монгол Улсын Их Хурлын албан мэдээлэл болох "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаарт нийтэлсэн бөгөөд төрийн мэдээлэлд нийтэлснээс хойш 10 хоногийн дараа буюу 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2.5% байсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 5%, алтны зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч 0-5%-ийг нэмж, нийт 9-10%-иар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулж алт олборлогч байгууллага, иргэдээс худалдан авч байна.

Монголбанк 2019 оны 3 дугаар сард 91 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 714 кг алт худалдан авч байснаас 623 кг дутуу буюу 87%-иар буурсан үзүүлэлттэй байна. Монголбанк 2019 оны 3 дугаар сард 448 кг цагаан мөнгө худалдан авсан.

2019 оны 3 дугаар сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 9 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 6 кг алтыг худалдаж авсан үзүүлэлттэй байна.

Монголбанкны алт худалдан авалт өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байгаа нь "Ашигт малтмалын тухай хууль"-д 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү болгосон хуулийн хугацаа 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр дуусгавар болсонтой холбоотой юм.

2019 оны 3 дугаар сарын байдлаар 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 110,109.38 төгрөг байлаа.

Энэ нь Лондонгийн үнэт металлын захын үнэ өндөр байгаатай холбоотой юм. 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Лондонгийн үнэт металлын захын алтны хаалтын ханш 1,309.70\$ /1 трой унци/ байна.

Эх сурвалж: Монголбанк

"Эрдэнэс Тавантолгой" ХК 50 сая дахь тонн нүүрсээ олборлолоо

"Эрдэнэс Тавантолгой" ХК I улиралд дөрвөн сая тонн нүүрс борлуулсан талаараа мэдээллээ.

Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 20 хувиар өссөн үзүүлэлт болов. Харин үнийн хувьд "Chalco" компанид нийлүүлж байгаа Зүүн цанхийн нүүрсийг нэг тонн тутмыг нь 63.32 ам.доллараар борлуулж байгаа. Тус үнэ нь 2018 оны II улиралд 61 ам.доллар болсон бөгөөд түүнээс хойш анх удаа буюу энэ оны I улиралд нэмэгджээ. Баруун цанхийн нүүрсийг нээлттэй сонгон шалгаруулалтаар борлуулж байгаа юм. Нэг тн нүүрсний ханш нь хамгийн сүүлийн байдлаар 71.25 ам.доллар байна.

"Эрдэнэс Тавантолгой" ХК 2010 оноос олборлолтоо эхэлсэн бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд 50 сая тонн нүүрс олборлоод байна. Компани 2019 онд 13 сая тонн нүүрс олборлож, борлуулахаар төлөвлөжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



Хөнгөн цагаан боловсруулагч компаниуд сэргээгдэх эрчим хүч ашиглахыг илүүд үзэж байна

Хөнгөн цагаан үйлдвэрлэлийн салбар жилд 1,700 тераватт цаг эрчим хүч ашиглаж байгаагийн 1,000 гаруй нь цахилгаан эрчим хүч байна.

Байгалийн хий, нүүрсний цахилгаан станцын нийлүүлдэг цахилгааныг түлхүү ашигладаг ганц салбар гэдгийг "Bloomberg New Energy Finance" мэдээллээ. Хөнгөн цагаан хайлуулах үйлдвэрүүд сэргээгдэх эх үүсвэрийн цахилгаан авах гэрээг сүүлийн үед түлхүү байгуулах болсон гэдгийг мөн онцолж байна. Ашиглаж байгаа нийт цахилгаан эрчим хүчнийх нь тал нь усан цахилгаан станцаас гаралтай байгаа юм. Мөн салхин цахилгаан станцуудтай гэрээ хийх нь нэмэгджээ. "Alcoa", "Horsk Hydro" зэрэг салбартаа тэргүүлэгч компаниуд энэ төрлийн худалдан авалт хийж эхлээд байна. Хөнгөн цагааны компаниуд үйлдвэрлэлд шаардлагатай дулаан бий болгохдоо нүүрстөрөгч бага ялгаруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүчийг сонгож байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.